



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№27 /471/

2023.02.07

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨЛӨӨ

Батлан хамгаалахын сайдын тушаалаар цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдсан бие бүрэлдэхүүн эх орондоо үнэнчрийн баталгаа болсон цэргийн тангаргаа өргөлөө.

Энэ удаагийн цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад 2023-2024 онд БНХАУ, Япон Улсын цэргийн их, дээд сургуульд суралцах бүрэлдэхүүн оролцож албан тушаалын зэрэглэлийн цолоо гардан авсны зэрэгцээ БХЯ-ны харьяа байгууллагуудад офицер, ахлагчийн албан тушаалд туршилтын хугацаанд томилогдон ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн хамрагдаж цэргийн тангаргаа өргөсөн юм.

Энэ үеэр БХЯ-ны ТЗУГ-ын хүний нөөцийн хангалт, төлөвлөлт хариуцсан шинжээч хурандаа



Д.Содномдаржаа хэлсэн үгэндээ Хэдий зүйлсээ улам бататгаж, цаг үргэлж богино ч гэлээ эл хугацаанд сурч мэдсэн цэргийн эрдэмд шамдан боловсорч

байхыг бие бүрэлдэхүүнд захиад цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад амжилттай хамрагдаж эр цэргийн тангаргаа өргөж байгаад баяртай байгаагаа илэрхийлэв.

Тангараг өргүүлэх ажиллагаанд ҮБХИС-ийн Сургалт бэлтгэл хариуцсан тэргүүн дэд захирал, доктор, хурандаа Б.Энхзоргол, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал ШУ-ны доктор, профессор хурандаа Б.Өлзийхуяг, ЦНДС-ийн захирал бригадын генерал Т.Лодойдамба, БХЯ-ны ТЗУГ-ын хүний нөөцийн хангалт, төлөвлөлт хариуцсан шинжээч хурандаа Д.Содномдаржаа, ахлах мэргэжилтэн дэд хурандаа Б.Ширэн болон цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөл оролцлоо.



## ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИКИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД...



Бүх цэргийн нэрт жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 130 жилийн ойг тохиолдуулан түүний нэрэмжит Зэвсэгт хүчний цэрэгжлийн гимнастикийн 2023 оны аварга шалгаруулах тэмцээнийг ҮБХИС зохион байгууллаа.

Тус тэмцээнд Зэвсэгт хүчний 30 орчим анги байгууллагын 280 гаруй цэргийн алба хаагчид оролцож сонс эргэлт, модон моринд малгай тавьж харайх, олон төрөлт болон чөлөөт хөдөлгөөн гэсэн төрлүүдээр 2 өдрийн турш өрсөлдөн аваргууд шалгаруулсан юм.



**Модон моринд малгай тавьж харайх төрөлд:**  
Нэгдүгээр байрт Цэрэгжлийн спортын мастер, ахлагч Д.Бат-Анар (016)  
Хоёрдугаар байрт Ахлах ахлагч Б.Балдорж (311)  
Хоёрдугаар байрт Сонсогч Э.Энхтүшиг (029)  
Сонс эргэх төрөлд:  
Нэгдүгээр байрт Ахлагч Э.Мөнх-Од (330)  
Хоёрдугаар байрт Цэрэгжлийн спортын мастер ахлагч Т.Сүхбат (330)  
Гуравдугаар байрт байр Цэрэгжлийн спортын дэд



мастер, ахлах ахлагч Б.Балжинням (350)  
**Эрэгтэй олон төрөлд:**  
Нэгдүгээр байрт Ахлах ахлагч З.Баяржаргал (311)  
Хоёрдугаар байрт Ахлах дэслэгч Н.Батдорж (186)  
Гуравдугаар байрт байр Ахлагч Г.Ууганбаяр (330)  
**Эрэгтэй тамирчдын багийн нийлбэр дүнгээр :**  
Нэгдүгээр байрт хурандаа Н.Бат-Эрдэнэ захирагчтай Зэвсэгт хүчний 330  
Хоёрдугаар байрт хурандаа Б.Олзбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 150  
Гуравдугаар байрт хурандаа Ж.Сүх-Очир захирагчтай Зэвсэгт хүчний 350 дугаар ангиуд шилдгээр шалгарсан бол

**Эмэгтэй олон төрөлд:**  
Нэгдүгээр байр ОУХМ дэд түрүүч Э.Элбэрэл (029)  
Хоёрдугаар байр Сонсогч Т.Ану (029)  
3 байр Ахлагч Б.Оюунтүлхүүр (186)  
**Эмэгтэй тамирчдын багийн нийлбэр дүнгээр:**  
Нэгдүгээр байрт бригадын генерал П.Жаргалан захиралтай ҮБХИС, Хоёрдугаар байрт хурандаа Ц.Төрмөнх захирагчтай Зэвсэгт хүчний 186  
Гуравдугаар байрт хурандаа Ж.Мөнхбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн тус тус амжилттай оролцож бусад нөхдөө манлайллаа.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,510	3,513
EUR	3,790	3,806
CNY	517	520
RUB	47.90	48.40
JPY	26.70	26.95
KRW	2.82	2.85

ЗУРХАЙ

2023.02.07 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

**Үс засуулбал:**  
Өнгө зүс доройтно  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.12-18.01  
**Барилдлага:**  
Арвидах  
**Шүтэн барилдлага:**  
Өтлөх үхэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 676,416,246

Эдгэрсэн

Нийт: 648,934,127

Нас барсан

Нийт: 6,773,425

Цахим шууданд

# ГАЛ УНТРААХ АЛБАНЫХАН НОМЫН ДУУ СОНСОВ



Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн гал түймэр унтраах албаны бие бүрэлдэхүүн 02 дугаар сарын 06-ны өдөр сургалтад хамрагдлаа.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын орлогч, дэд хурандаа А.Сэргэлэнгээр ахлуулсан 12 алба хаагч "Галын аюулгүй байдлын тухай хууль", "Гал унтраах дүрэм", "Гал унтраах дадлага" гэсэн сэдвүүдээр сургалт, дадлагыг зохион байгуулж, гал унтраах албаны үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн юм.

Ахмад А.АЛТАНХУЯГ

# "АЛДАР"-ЫНХАН ӨНГӨЛӨВ



"Жем интернэшнл" группийн нэрэмжит "Улсын харцага цолны хүндэтгэл"-ийн улс, аймгийн алдар цолтой 256 бөхийн барилдаанд Ховд аймгийн Зэрэг сумын харьяат, "Алдар" спорт хороо, Ховд дэвжээний бөх, улсын заан, ахлах дэслэгч Б.Бат-Өлзий түрүүлж, Архангай аймгийн Булган сумын харьяат, "Алдар" спорт хороо, "Бөхбилэгт" дэвжээний бөх, улсын арслан, ахлах дэслэгч Р.Пүрэвдагва үзүүрлэв.

Их шөвгийн дөрөвт Завхан

аймгийн Яруу сумын харьяат, "Хилчин" спорт хороо, "Даян" дэвжээний бөх, МУГТ, улсын заан М.Лхагвагэрэл, Төв аймгийн Баянцогт сумын харьяат "Дүнжингарав" дэвжээний бөх, улсын харцага Ө.Даваабаатар нар шалгарлаа.

Дунд шөвгийн наймд улсын арслан Э.Оюунболд, улсын харцага Л.Лха-Очир, Ц.Мөнхбаяр, цэргийн заан Ө.Батуурь нар үлдэв.

Дэд хурандаа Т.ӨСӨХ-ИРЭЭДҮЙ

# АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТАЙ ХАМТАРСАН СУРГАЛТААР ...



Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Өмнөговь аймгийн Онцгой байдлын газартай хамтран "Гал түймрээс урьдчилан сэргийлэх нь", "Гал унтраах арга дараалал" сэдэвт хичээлийг 2 дугаар сарын 06-ны өдөр ангийн бие бүрэлдэхүүн болон орон тооны бус галын салаа, хугацаат цэргийн алба хаагчдад зохион байгуулж явууллаа.

Тус хичээлийг Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах 21 дүгээр ангийн захирагч, ахмад Д.Одхүү удирдан явуулсан юм.

Ахмад Д.Одхүү гал түймэр түүний дэгдэлт, гал унтраагуурын бүтэц, байгууллага бүрт байх ёстой гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж зэвсэглэлийн байрлалын талаар хамгийн эхэнд мэдээлэл өгөв. Мөн гал түймэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг дасгалаар гүйцэтгүүлж, алба хаагч бүрт аюулгүй байдлын мэдлэг олгосон үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.

Дэслэгч Б.БАТЗАЯА



# ОФИЦЕРУУД МӨРДЭС НЭГТ НӨХДӨДӨӨ ТАЛАРХЛАА ИЛЭРХИЙЛЛЭЭ



Зэвсэгт хүчний хэмжээнд өрнүүлж байгаа билээ.

"Мөрдэс нэгт нөхрийнхөө гэргийг мөрөөс нь түшээд босгоё, бүгдээрээ" хандивын аянд Зэвсэгт хүчний нэгтгэл ангиуд, мэргэжил нэгт нөхөд, онжавууд, сайхан сэтгэлт иргэд идэвхтэй оролцож, тусламжийн гараа сунгасаар байгаа юм.

Хандивын аянд одоогийн байдлаар Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Зэвсэгт хүчний 014, 120, 123, 234, 167, 186, 326, 336 дугаар ангиудын хамт олон нэгдэж, Зэвсэгт хүчнийхээ бэрүүдийг хурдан эдгэхийг хүсэн ерөөсөн юм. Мөн дэд хурандаа Д.Батсайхантай нэгэн цагт хамт ажиллаж байсан Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн журмын нөхөд, хошууч П.Отгонбаатартай хамт ажиллаж байсан Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн журмын нөхөд нь тусламжийн гараа сунгав.



Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, дэд хурандаа Д.Батсайханы гэргий Н.Эрдэнэцэцэг маш ховор тохиолдлын нарийн гэдэсний хавдар, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Сургалтын албаны дарга, хошууч П.Отгонбаатарын гэргий Д.Солонго нь савны хорт хавдрын гуравдугаар үе гэж оношлогдож, гадаадад хагалгаа, эмчилгээ хийлгэх болсонтой холбогдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас сайн үйлсийн аяныг

Ханийхаа хамтран зүтгэгч мөрдэс нэгт нөхдийнх нь энэрэнгүй сайхан сэтгэлд дэд хурандаа Д.Батсайхан, хошууч П.Отгонбаатар нарын гэргий нар талархлаа илэрхийлж "Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүнд маш их баярлаж байна. Та бүхнийхээ сэтгэлийн гал, итгэлийн хүчээр бид удахгүй хөл дээрээ босож, эрүүл энх болно оо. Дайны голомтод нөхрөө хаяж зугтдаггүй шиг өвдөж шаналсан офицеруудынхаа гэргий нарт тусалж байгаа үйлсэд нь талархаад баршгүй" гээд ажил, албанд нь өндөр амжилт хүссэн юм.

Ташрамд дурдахад, дэд хурандаа Д.Батсайханы гэргий Н.Эрдэнэцэцэг БНХАУ-д эмчилгээ хийлгэж байгаа бөгөөд удахгүй хагалгаандаа орох бол хошууч П.Отгонбаатарын гэргий Д.Солонго

БНТУ-ын эмнэлэгт эмчилгээгээ эхлүүлээд байна.

Үйлс, зорилго нэгтэй офицеруудынхаа аз жаргалтай гэр бүлд элэг бүтэн амьдрал бэлэглэхэд нэгдэж, хандив өргөхийг хичээнгүйлэн хүсэж байна. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

Дэд хурандаа Д.БАТСАЙХАНЫ ГЭР БҮЛ  
ХАРИЛЦАХ УТАС: 86117527, 99823846  
ДАНС: Н. Эрдэнэцэцэг (Хаан банк 5630498525), (Капитрон банк 3022007812)

Хошууч П.ОТГОНБААТАРЫН ГЭР БҮЛ  
ХАРИЛЦАХ УТАС: 95038800, 89040408  
ДАНС: Д.Солонго (Хаан банк 5018163641)  
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

## Хандивын аян

Намайг Д.Солонго гэдэг. Миний хувьд нөхөр хоёр хүүхдийн хамт амьдардаг бөгөөд 2021 оны хоёрдугаар сард анх савны хорт хавдарын гуравдугаар үе гэж оношлогдсон.

Савны хорт хавдар гэж оношлогдох үед би 38 нөдөлгөй жирэмсэн байсан бөгөөд яаралтай кесерв хагалгаагаар хүүхдээ төрүүлсэн. Хүүгээ төрүүлээд нэг сар болоод хөхнөөс нь гаргасан. Түүнээс хойш хими, туяаны эмчилгээ зэрэг эзэлсэн. Энэ хоёр жилийн хугацаанд нийт 29 удаа туяа эмчилгээ, 16 удаа хими эмчилгээ хийлгэсэн боловч хавдар нь бага аарцагданаа мэдрэлийн судас дарж үсэрхийлсний улмаас баруун хөл өдрөөс өдөрт бага багаар мэдээ алдаж суумгай болсон. Өөрөө алхаж гишгэх боломжгүй болоод тэргэцэр дээр сууж байна. Мөн туяа эмчилгээний дараа хүчдрэл гарч баруун бөөр усжилт үүсэн гуурс тавиглаад байна. Иймээс би Турк улсын Медикалпарк эмнэлэгт өөрийн оношоо явуулж тэнд 100 хувь эмчлэгдэх боломжтой гэсэн хариу авсан эмчилгээний зардал 80-90 сая болох тул элэг нэгт монголчууд та бүхнээсээ хандив гуйж байна.

Дам дэмэндээ дээс эрчэндээ гэж монгол ардын зүр цэцэн үгийг санаж хоёр урийн минь элэг бүтэн байлгахын төлөө надад тусламжийн гараа сунгаач гэж хүсэж байна.

ХАНДИВЫН ДАНС: 5018163641 Д.Солонго  
ХОЛБОГДОХ УТАС: 89040408 95038800